



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2024/55/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот  
2024 оны 02 дугаар сар 24

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  
Ахлах аудитор М.Алтантуяа  
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК  
Захирал Г.Саранчимэг  
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com  
Аудитор: О.Мандах  
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	8
4.АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.5.1 Завсрын аудитын талаар .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	115
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Төлбөрийн акт.....	16
5.2 Албан шаардлага.....	17
6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



ЖИНСТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Л.СУГАРМАА ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.23, № 2/34

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 476,455.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 373,618.7 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 955.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, харилцах дансанд 101,885.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**5020151**

Аудитаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 8 дугаар сарын мэдээнд цалин илүү мэдээлж 2,497.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй, бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дээд шатны байгууллагаас 81.0 хувьтай дүгнэсэн байна.

Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>122,223,788.72</b>	<b>137,696,520.63</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>92,360,020.72</b>	<b>101,885,635.63</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>92,360,020.72</b>	<b>101,885,635.63</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>92,360,020.72</b>	<b>101,885,635.63</b>
31211	Төрийн сангийн харилцах	92,360,020.72	101,885,635.63
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0</b>	<b>2,799,777.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	2,799,777.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>29,863,768.00</b>	<b>33,011,108.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>28,170,768.00</b>	<b>32,522,808.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	25,078,268.00	31,488,808.00
35130	Эм боох материал	3,092,500.00	1,034,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>1,693,000.00</b>	<b>488,300.00</b>
35410	Бичиг хэргийн материал	33,300.00	33,300.00
35420	Аж ахуйн материал	0	50,000.00
35460	Хүнсний материал	1,659,700.00	405,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>631,989,144.23</b>	<b>604,202,555.47</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>631,989,144.23</b>	<b>604,202,555.47</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>625,551,144.23</b>	<b>597,764,555.47</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	657,333,822.28	657,333,822.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-69,279,607.19	-86,901,837.59
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	42,454,161.00	42,454,161.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19,626,433.17	-25,835,512.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,681,821.15	33,681,821.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,012,619.84	-22,967,899.04
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>6,438,000.00</b>	<b>6,438,000.00</b>
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,438,000.00	6,438,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>754,212,932.95</b>	<b>741,899,076.10</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>261,466.03</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>261,466.03</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0</b>	<b>261,466.03</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	133,766.03
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0</b>	<b>127,700.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0	127,700.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>754,212,932.95</b>	<b>741,637,610.07</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>754,212,932.95</b>	<b>741,637,610.07</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	111,802,083.00	111,802,083.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	111,802,083.00	111,802,083.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>288,671,929.06</b>	<b>276,096,606.18</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-465,626,381.67	288,671,929.06
51220	Тайлант үеийн үр дүн	754,298,310.73	-12,575,322.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	353,738,920.89	353,738,920.89
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>754,212,932.95</b>	<b>741,899,076.10</b>



Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлан оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,046,563,435.63	387,428,340.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	688,953,735.63	3,399,040.00
120	Нийтлэг татварын бус орлого	688,953,735.63	3,399,040.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	70,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	659,199,392.63	0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	29,754,343.00	3,329,040.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	357,609,700.00	384,029,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	320,720,800.00	355,152,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	320,720,800.00	355,152,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,888,900.00	28,876,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,888,900.00	28,876,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	292,265,124.90	400,003,662.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	292,265,124.90	400,003,662.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	289,572,608.42	397,313,042.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,927,136.51	261,641,636.95
210101	Үндсэн цалин	118,102,978.81	194,508,854.66
210102	Нэмэгдэл	46,020,049.01	52,981,682.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0
210104	Урамшуулал	6,968,401.45	14,151,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,835,707.24	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,059,479.51	32,156,793.17
210201	Тэтгэврийн даатгал	15,513,248.89	20,800,087.17
210202	Тэтгэмжийн даатгал	1,377,648.32	3,671,661.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,422,391.28	1,952,739.00
210204	Ажилгүйдлийн даатгал	331,372.35	489,914.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,414,818.67	5,242,392.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,881,169.00	27,121,879.00
210301	Гэрэл, цахилгаан	1,645,829.00	2,919,511.00
210302	Түлш, халаалт	19,235,340.00	23,002,368.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,886,800.00	8,241,400.00
210401	Бичиг хэрэг	2,998,250.00	2,916,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,143,950.00	778,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	90,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,744,600.00	590,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0	3,705,850.00
2105	Нормативт зардал	25,112,475.00	36,544,835.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	2,058,500.00
210502	Хоол, хүнс	25,112,475.00	34,486,335.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	375,000.00	0
210604	Урсгал засвар	375,000.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,542,800.00	720,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	370,100.00	450,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,172,700.00	270,000.00

**Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,787,748.40</b>	<b>30,886,498.76</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,127,500.00	3,099,910.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	450,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,210,248.40	27,786,588.76
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,692,516.48</b>	<b>2,690,620.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0</b>	<b>1,735,599.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	1,735,599.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,692,516.48</b>	<b>955,021.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,692,516.48	955,021.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>754,298,310.73</b>	<b>-12,575,322.88</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>754,298,310.73</b>	<b>-12,575,322.88</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлан оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>357,609,700.00</b>	<b>384,099,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0</b>	<b>70,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0</b>	<b>70,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0</b>	<b>70,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	70,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>357,609,700.00</b>	<b>384,029,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>320,720,800.00</b>	<b>355,152,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	320,720,800.00	355,152,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>36,888,900.00</b>	<b>28,876,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,888,900.00	28,876,900.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>265,249,679.28</b>	<b>374,573,685.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>265,249,679.28</b>	<b>374,573,685.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>262,557,162.80</b>	<b>371,883,065.09</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>182,012,514.29</b>	<b>256,036,734.71</b>
210101	Үндсэн цалин	118,188,356.59	178,239,407.02
210102	Нэмэгдэл	46,020,049.01	63,646,227.69
210104	Урамшуулал	6,968,401.45	14,151,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,835,707.24	0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,059,479.51</b>	<b>40,427,706.38</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,513,248.89	25,628,406.38
210202	Тэтгэмжийн даатгал	1,377,648.32	3,699,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,422,391.28	2,959,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	331,372.35	739,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,414,818.67	7,399,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>21,881,169.00</b>	<b>27,121,879.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,645,829.00	2,919,511.00
210302	Түлш, халаалт	19,235,340.00	23,002,368.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,200,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,024,000.00</b>	<b>33,231,635.00</b>
210502	Хоол, хүнс	24,024,000.00	33,231,635.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>800,000.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	800,000.00

**Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	813,000.00	360,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	813,000.00	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,267,000.00	13,905,110.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,567,000.00	12,303,010.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,700,000.00	1,602,100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,692,516.48</b>	<b>2,690,620.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	1,735,599.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	1,735,599.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,692,516.48	955,021.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,692,516.48	955,021.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>92,360,020.72</b>	<b>9,525,614.91</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>92,360,020.72</b>	<b>9,525,614.91</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	92,360,020.72
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	92,360,020.72	101,885,635.63

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	111,802,083.00	353,738,920.89	-465,626,381.67	-85,377.78
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	111,802,083.00	353,738,920.89	-465,626,381.67	-85,377.78
4	Тайлант үеийн үр дүн	0	0	754,298,310.73	754,298,310.73
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	111,802,083.00	353,738,920.89	288,671,929.06	754,212,932.95
6	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	111,802,083.00	353,738,920.89	288,671,929.06	754,212,932.95
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	111,802,083.00	353,738,920.89	288,671,929.06	754,212,932.95
8	Тайлант үеийн үр дүн	0	0	-12,575,322.88	-12,575,322.88
9	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	111,802,083.00	353,738,920.89	276,096,606.18	741,637,610.07

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/**

Эдийн засгийн код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	476,455,300.0	373,618,664.1	102,836,635.9	78.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	476,455,300.0	373,618,664.1	102,836,635.9	78.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	474,719,700.0	371,883,065.1	102,836,634.9	78.3

**Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>343,016,300.0</b>	<b>256,036,734.7</b>	<b>86,979,565.3</b>	<b>74.6</b>
210101	Үндсэн цалин	224,024,200.0	178,239,407.0	45,784,793.0	79.6
210102	Нэмэгдэл	104,841,000.0	63,646,227.7	41,194,772.3	60.7
210104	Урамшуулал	14,151,100.0	14,151,100.0	0.0	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,629,800.0</b>	<b>40,427,706.4</b>	<b>12,202,093.6</b>	<b>76.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	35,788,400.0	25,628,406.4	10,159,993.6	71.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,210,400.0	3,699,900.0	510,500.0	87.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,368,200.0	2,959,800.0	408,400.0	87.9
210204	Ажилгүйдлийн даатгал	842,000.0	739,900.0	102,100.0	87.9
210205	Эрүүл мэндийн даатгал	8,420,800.0	7,399,700.0	1,021,100.0	87.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,076,900.0</b>	<b>27,121,879.0</b>	<b>955,021.0</b>	<b>96.6</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,794,500.0	2,919,511.0	874,989.0	76.9
210302	Түлш, халаалт	23,082,400.0	23,002,368.0	80,032.0	99.7
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.0	1,200,000.0	0.0	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>36,056,400.0</b>	<b>33,231,635.0</b>	<b>2,824,765.0</b>	<b>92.2</b>
210502	Хоол, хүнс	36,056,400.0	33,231,635.0	2,824,765.0	92.2
2106	<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>800,000.0</b>	<b>800,000.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
210602	Урсгал засвар	800,000.0	800,000.0	0.0	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>534,000.0</b>	<b>360,000.0</b>	<b>174,000.0</b>	<b>67.4</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	534,000.0	360,000.0	174,000.0	67.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,606,300.0</b>	<b>13,905,110.0</b>	<b>-298,810.0</b>	<b>102.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,004,200.0	12,303,010.0	-298,810.0	102.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,602,100.0	1,602,100.0	0.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,735,600.0</b>	<b>1,735,599.0</b>	<b>1.0</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,735,600.0</b>	<b>1,735,599.0</b>	<b>1.0</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,735,600.0	1,735,599.0	1.0	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>476,455,300.0</b>	<b>384,099,300.0</b>	<b>92,356,000.0</b>	<b>80.6</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>355,152,400.0</b>	<b>355,152,400.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	355,152,400.0	355,152,400.0	0.0	100.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>28,876,900.0</b>	<b>28,876,900.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
320001	Орон нутгийн төсвөөс	28,876,900.0	28,876,900.0	0.0	100.0
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>92,426,000.0</b>	<b>70,000.0</b>	<b>92,356,000.0</b>	<b>0.1</b>
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.0	70,000.0	0.0	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	92,356,000.0	0.0	92,356,000.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	92,360,020.7	-92,360,020.7	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	101,885,635.6	101,885,635.6	0.0
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	0.0	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>17.0</b>	<b>17.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9.0	9.0	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	7.0	7.0	0.0	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жинст сумын Цэцэрлэг нь Бага насны хүүхдийг асран хамгаалах, хүмүүжүүлэх сургах цогц үйл ажиллагаа явуулж хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмших

хөгжлийг дэмжих, сургуульд орох бэлтгэлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Тайлант онд Хүүхдийн хүсэл сонирхол, хэрэгцээнд тулгуурласан идэвхтэй, чөлөөт үйл явцад суралцах, хөгжих хамгаалагдсан ээлтэй орчин байж, тэднийг хайрлан хүндэтгэж, бүх талын хөгжлийг дэмжинэ гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Жинст сумын Цэцэрлэг нь 2023 онд удирдах 1, гүйцэтгэх 9, үйлчлэх 7 ажилтан нийт 17 орон тоо батлагдаж, 3 үндсэн бүлэгтэй 86 хүүхдийг хамруулан цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Тайлант онд 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй БСШУСпортын сайдын 2017 оны 02 дугаар сарын 07-ны А/40 дүгээр тушаалаар баталсан Боловсролын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлог тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,313,8 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	92,360.0	101,885.6	9,525.6
Авлага		2,799.8	2799.8
Бараа материал	29,863.8	33,011.1	3,147.3
Үндсэн хөрөнгө	740,107.8	740,107.8	0.00
хуримтлагдсан элэгдэл	-108,118.7	-135,905.2	-27,786.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>754,212.9</b>	<b>741,899.1</b>	<b>-12,313.8</b>
Өр төлбөр		261.5	261.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	754,212.9	741,637.6	-12,575.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>754,212.9</b>	<b>741,899.1</b>	<b>-12,313.8</b>

Эх сурвалж: Жинст сумын цэцэрлэгийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Жинст сумын цэцэрлэгийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь бараа материал, мөнгөн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 92,360.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 101,885.6 мянган төгрөгийн өмнөх оноос 9,525.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 44,354.5 мянга, Боловсролын ерөнхий газраас 3,329.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлого авч үйл ажиллагаанд 43,945.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эрхлэгчийн 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/75 дугаар тушаалаар 590,5 мянган төгрөгийн бараа материал актлаж бараа материалын үлдэгдэл 3,147.3 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан байна.

Тайлант онд авлага 2.799.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь НДШ-ийн төлөлтийн тайланд цалин илүү мэдээлсэнтэй холбоотой үүссэн авлага байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант онд өглөг 261.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өглөгийг тайланд тусгаагүйг аудитын явцад тусгуулсан өглөг болно.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 12,575.3 мянган төгрөгөөр буурч, 741,637.6 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, өглөг 261.5 мянган төгрөгөөр өссөн тайлант үеийн үр дүн 12,575.3 мянган төгрөгөөр буурч 741,899.1 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 285,965.0 мянган төгрөгөөр төлөвлөж, зарлагыг 285,965.0 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 32,102.9 мянган төгрөгөөр буурч 253,862.1 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 355,152.4 мянган төгрөг болж 101,290.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71801 (Сургуулийн өмнөх боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 355,152.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урьд оны үлдэгдлээс санхүүжих 92,356.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 70.0 мянга, орон нутгийн санхүүжилтээр 28,876.9 мянган төгрөг нийт 476,455.3 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 373,618.7 мянган төгрөгийг зарцуулж, 101,855.6 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 28,876.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 96.7 хувь буюу 27,921.9 мянган төгрөгийг зарцуулж, 955.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол				
1	81605 Эрүүл мэндийн дэмжих зардал	800.0	800.0	-	100.0
2	81807 Хүүхдийн хоолны зардал	36,056.4	33,231.6	2,824.7	92.2
3	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчны зардал	2,666.0	2,666.0	-	100.0

**Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

4	81823 Боловсролын байгууллагын багшийн зардал	-	-	-	
5	81834 Боловсролын стандарт сургалтын зардал	282,284.2	183,227.4	99,056.8	64.9
6	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	109,486.0	109,486.0	-	100.0
7	81823 Боловсролын байгууллагын багш	801.1	801.1	-	100.0
8	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын төлбөр	70.0	70.0	-	100.0
9	81833 Явуулын багшийн үйлчилгээ	1,632.0	1,632.0	-	100.0
10	81832 Нүүдлийн бүлэг	13,782.7	13,782.7	-	100.0
11	80812 Нийтлэг үйлчилгээ	28,876.9	27,921.9	955.00	96.7
	<b>Нийт дүн</b>	<b>476,455.3</b>	<b>373,618.7</b>	<b>102,836.6</b>	<b>78.4</b>

Эх сурвалж: 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жинст сумын Цэцэрлэг нь тайлант онд цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 36,056.4 мянган төгрөг төсөв батлагдаж 1 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын болон гэрээгээр Өнөрбаян богд ХХК-тай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 33,231.6 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.



Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг 2023 оны 04 сарын 5 хүртэл Цэцэрлэгийн эрхлэгч Б.Өлзийдүүрэн, 4 сарын 05-ны өдрөөс Л.Сугармаа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Мандах нар зурж, нярваар Б. Дүүрэнбилэг 2023.4.30 хүртэл , 2023.5.1-нээс Н.Болортуяа нар ажиллажээ.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны 3 дугаар улирлын зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын нийт зардлын 258,707.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,880.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 2,910.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 134,274.7 мянган төгрөгийн 6 гүйлгээ, зарлагын 55,848.7 мянган төгрөгийн 15 гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

*Завсрын аудит хийгдээгүй болно.*



#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Номгон аудит ХХК-ийн аудитор О.Мандах гүйцэтгэж, 30,500.0 мянган төгрөгийн албан шаардлага, 2,018.3 мянган төгрөгийн актыг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2018.3	1	2018.3	100
Албан шаардлага	2	30500.0	2	30,500.0	100
Зөвлөмж					
Нийт дүн	3	32518.3	3	32518.3	100.0

Эх сурвалж: Жинст сумын Цэцэрлэгийн 2023.06.15-ны өдрийн мөнгө тушаасан баримт

Аудитаар өгсөн төлбөрийн акт 2018.3 мянган төгрөгийг 2023.6.15-нд төл барагдуулсан албан шаардлагыг биелүүлж ажиллажээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд аудитын явцад 436.1 мянган төгрөгийн 2 алдаа илэрсэнийг залруулав. Үүнд:

1 ажилтны цалингаас 303,2 мянган төгрөгийг суутгаагүй илүү олгосоныг авлагаар, ХАОТтатварт 69,9 мянга, ҮЭ-ийн өглөг 63.8 мянган төгрөгийг өглөгөөр тусгаагүй байсныг санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Аудитаар нийт 2,497.5 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрсэнд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

1.Илрүүлэлт: Байгууллагын 8 сарын Нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээнд нэр бүхий 8 ажилтны цалинг 11,399.9 мянган төгрөгөөр илүү, 1 ажилтны амралтын цалин 993,9 мянган төгрөгийг дутуу мэдээлсэнээс 2,497.5 төгрөгийн зөрүү үүссэнийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй.

Энэ нь нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1,1 дэх з ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд ногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж хугацаанд нь төлөх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1” Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээг залруулах илүү төлөгдсөн 2,497.5 мянган төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх. төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

2.Илрүүлэлт: Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаагаар Жинст сумын Цэцэрлэг нь 3250 м2 талбай бүхий газрыг 2015 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 13 дугаар захирамжаар олгосон байхад байгууллагын санхүүгийн тайланд 3219 м2-аар бүртгэснийг тулган шалгахад 31 м2 зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын санхүүгийн тайланд биет бус хөрөнгөнд газрын зөрүүг нэмж бүртгэн зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1 ажилтны цалингаас 303,2 мянган төгрөгийг суутгаагүй илүү олгосоныг авлагаар, ХАОТ татварт 69,9 мянга, ҮЭ-ийн өглөг 63.8 мянган төгрөгийг өглөгөөр тусгаагүй	2	436.9	2	436.9			2	436.9				
Дүн	2	436.9	2	436.9			1	436.9				

**Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил								
Байгууллагын 8 сарын Нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээнд нэр бүхий 8 ажилтны цалинг 11,399,938.0 төгрөгөөр илүү, 1 ажилтны амралтын цалин 993,864.0 төгрөгийг дутуу мэдээлсэнээс 2,497.5 төгрөгийн зөрүү үүссэнийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй	1	2497.5	1	2497.5			0	0
Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаагаар Жинст сумын Цэцэрлэг нь 3250 м2 талбай бүхий газрыг 2015 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 13 дугаар захирамжаар олгосон байхад байгууллагын санхүүгийн тайланд 3219 м2-аар бүртгэлээс 31 м2 зөрүүтэй	1				1		0	0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>2497.5</b>		<b>2,497.5</b>	<b>1</b>			

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo---





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 59/14210573/БНА/2024  
/557 НА-СТА-ТӨРЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын 8 сарын Нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээнд нэр бүхий 8 ажилтны цалинг 11,399,938 төгрөгөөр илүү, 1 ажилтны амралтын цалин 993,864 төгрөгийг дутуу мэдээлсэнээс 2,497,457 төгрөгийн зөрүү үүссэнийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1,1 дэх з ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд ногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж хугацаанд нь төлөх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1” Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтуудыг гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй “Ниицсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.4 дахь “Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Нийгмийн даатгалын мэдээ тайланг хугацаанд нь үнэн зөв мэдээлээгүйгээс 2,497,457 (Хоёр сая дөрвөн зуун ерэн долоон мянга дөрвөн зуун тавин


5050121

долоон) төгрөгийн авлага үүссэн бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээг залруулж илүү төлөгдсөн 2,497,457 (Хоёр сая дөрвөн зуун ерэн долоон мянга дөрвөн зуун тавин долоон) төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусадтатвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жинст сумын Цэцэрлэгийн эрхлэгч Л. Сугармаа, нягтлан бодогч Б. Мандах нарт хариуцуулав<sup>1</sup>.

### ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>2</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР:  О. МАНДАХ

<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 2 сарын 23 өдөр

Дугаар 97/14210573/5НА/2024  
/55/НА-СТА - ПИЦЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жинст сумын Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаагаар Жинст сумын Цэцэрлэг нь 3250 м2 талбай бүхий газрыг 2015 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 13 дугаар захирамжаар олгосон байхад байгууллагын санхүүгийн тайланд 3219 м2-аар бүртгэснийг тулган шалгахад 31 м2 зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын санхүүгийн тайланд биет бус хөрөнгөнд газрын зөрүүг нэмж бүртгэн зөрчлийг арилган, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох

5040185

баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Жинст сумын Цэцэрлэгийн эрхлэгч Л. Сугармаа, нягтлан бодогч Б. Мандах нарт даалгав<sup>2, 3</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН:

АУДИТОР

О. МАНДАХ

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно